

## **ДОГОВОР О СОТРУДНИЧЕСТВЕ**

**между Институтом географии и геоэкологии Академии наук Монголии и Институтом систем энергетики имени Л.А. Мелентьева Сибирского отделения Российской Академии наук**

Институт систем энергетики им. Л.А.Мелентьева Сибирского отделения Российской Академии Наук (ИСЭМ СО РАН) в лице **И.о. директора Стенникова В.А.**, действующего на основании доверенности, и Институт географии и геоэкологии Академии наук Монголии (ИГГ АНМ) в лице **директора Б.Батбуяна**, действующего на основании Устава ИГГ АНМ, именуемые в дальнейшем “Стороны”, руководствуясь взаимным желанием сотрудничать в области науки и технологии, а также по убеждению, что это сотрудничество отвечает интересам обеих организаций, заключили настоящий Договор.

### **1. ЦЕЛЬ ДОГОВОРА**

Установление дружественных отношений и развитие научно-технического сотрудничества между Институтом географии и геоэкологии Академии наук Монголии и Институтом систем энергетики имени Л.А.Мелентьева Сибирского отделения Российской Академии Наук в совместных исследованиях и разработках, представляющих взаимный интерес.

### **2. ОСНОВНЫЕ ЗАДАЧИ ДОГОВОРА**

Основными задачами договора являются:

- Проведение научных и прикладных исследований в интересах обеих Сторон;
- Интеграция кадрового потенциала и материально-технических ресурсов Сторон для обеспечения выполнения задач, стоящих на современном этапе перед научными учреждениями обеих стран;
- Повышение квалификации и профессиональная переподготовка специалистов в областях и направлениях совместных исследований с учетом современных достижений науки, передового отечественного и зарубежного опыта и требований практики;
- Использование материальной базы Сторон для осуществления образовательной деятельности, стажировок, обмена информацией и специалистами, апробации и внедрения в практику результатов научно-исследовательских работ.

### **3. СОДЕРЖАНИЕ ДОГОВОРА**

Предметом Договора является обеспечение сотрудничества между договаривающимися Сторонами, которые будут всемерно способствовать реализации основных положений настоящего Договора и заключенных на его основе конкретных договоров между Сторонами при выполнении совместных исследований.

### **4. УСЛОВИЯ СОТРУДНИЧЕСТВА**

1. Стороны будут осуществлять обмен информацией, опытом и развивать взаимовыгодное научно-техническое сотрудничество.

Реализация всех форм сотрудничества будет проводиться на основе конкретных договоров (контрактов), согласованных проектов и рабочих программ между институтами, отдельными подразделениями и специалистами, разрабатываемых на заранее оговоренных условиях и в установленные сроки.

Рабочие программы и планы должны будут детально определять направления и формы сотрудничества, включая его финансовое обеспечение.

2. Стороны планируют осуществлять сотрудничество в следующих областях:

- Проведение конкретных научных исследований по согласованной тематике;
- Совместная подготовка научных докладов, статей, монографий;
- Совместное проведение международных научных семинаров, симпозиумов и конференций;
- Обмен научно-технической информацией;
- Подготовка и защита кандидатских и докторских диссертаций;
- Организация научных стажировок, по просьбе монгольской стороны обучение и подготовки кадров

При осуществлении сотрудничества по настоящему Договору Стороны будут руководствоваться положениями правовых документов, действующих между Правительствами России и Монголии, существующим законодательством наших стран. Порядок обмена специалистами будут определяться в соответствии с договоренностями в пределах финансовых возможностей сторон.

## **5. ВЫПОЛНЕНИЕ СОВМЕСТНЫХ ПРОЕКТОВ**

Совместные научные исследования с привлечением как своих сотрудников, так и сотрудников сторонних организаций, будут проводиться по дополнительным соглашениям и договорам, в том числе по Международным проектам.

## **6. ФИНАНСИРОВАНИЕ**

В рамках настоящего договора Стороны самостоятельно несут свои затраты, связанные с реализацией совместных проектов, если нет другой договоренности, согласованной Сторонами в письменной форме.

Возможные условия и сроки финансирования конкретных проектов определяются обеими Сторонами до начала их выполнения в соответствии со статьей 5.

## **7. ВСТУПЛЕНИЕ В СИЛУ, ИЗМЕНЕНИЕ И ПРЕКРАЩЕНИЕ ДЕЙСТВИЯ ДОГОВОРА**

По согласованию обеих Сторон в Договор могут быть внесены изменения и дополнения. Подписанный Договор не исключает возможность проведения других мероприятий и направлений сотрудничества, которые должны быть согласованы в письменном виде.

Настоящий Договор вступает в силу с момента его подписания и является бессрочным. Договор может быть расторгнут по желанию одной из сторон при уведомлении другой

стороны за шесть месяцев о прекращении своего участия в Договоре, со дня отправки письменного предупреждения. Начатые и незавершенные работы доводятся до конца независимо от окончания срока действия Договора в соответствии с ранее достигнутыми договоренностями.

Договор составлен в двух экземплярах на русском языке и двух экземплярах на монгольском языке, причем каждый экземпляр имеет одинаковую юридическую силу.

### ЮРИДИЧЕСКИЕ АДРЕСА СТОРОН

ИГГ АНМ:

Улаанбаатар, Монголия

Тел: (976)-11-322187

Факс: (976)-11-322187

info@geo-eco.mn

ИСЭМ СО РАН:


г. Иркутск, ул.Лермонтова, 130

Тел:+7(3952) 42-47-00

Факс: +7(3952) 42-44-44

e-mail: INFO@ISEM.IRK.RU

Подпись:  
От ИГГ АНМ,  
Директор Б. Батбуян



“ ”

Подпись:  
От ИСЭМ СО РАН,  
И.о. директора В.А. Стенников



“ ”

**Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Газарзүй-геоэкологийн хүрээлэн, ОХУ-ын Шинжлэх Ухааны Академийн Сибирийн салбарын Л.А.Мелентьевын нэрэмжит Системын Эрчим Хүчний Хүрээлэн хооронд хамтран ажиллах гэрээ**

Нэг талаас ОХУ-ын Шинжлэх Ухааны академийн Сибирийн салбарын Л.А.Мелентьевын нэрэмжит Системын Эрчим Хүчний Хүрээлэнг төлөөлж итгэмжлэлийн үндсэн дээр захиралын үүрэг гүйцэтгэгч В.А.Стенникова, нөгөө талаас Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэнг төлөөлж хүрээлэнгийн дүрэмд заасан дагуу захирал Б.Батбуян нар шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах чин хүсэл эрмэлзэл, хамтын ажиллагаа нь хоёр хүрээлэнгийн сонирхолд нийцэж буйг үндэс болгон энэхүү гэрээг байгуулав.

**1. Гэрээний зорилго**

ОХУ-ын Шинжлэх Ухааны академийн Сибирийн салбарын Л.А.Мелентьевын нэрэмжит Системын Эрчим Хүчний Хүрээлэн ба Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэн хооронд хоёр талын нийтлэг сонирхлын хүрээнд хамтарсан судалгаа явуулах замаар түншийн харьцааг бий болгох, шинжлэх ухаан, технологийн салбарт хамтын ажиллагааг өрнүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

**2. Гэрээний үндсэн зорилтууд**

Энэхүү гэрээний үндсэн зорилтуудыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Хоёр талын сонирхолд нийцсэн суурь болон хавсрага судалгааг хийж гүйцэтгэх;
- Хоёр талын эрдэм шинжилгээний байгууллагын өмнө тавигдаж буй орчин үеийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай хүний нөөц болон материал-техникийн нөөцийг бэхжүүлэх;
- Үндэсний болон олон улсын түвшинд гарч буй орчин үеийн шинжлэх ухаан, техникийн хөгжлийн дэвшлийг харгалзан хамтран ажиллах судалгааны чиглэлийн хүрээнд эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжилтний ур чадварыг сайжруулах, мэргэжлийн бэлтгэлийг нэмэгдүүлэх;
- Талуудын материал, техникийн базыг сургалт, дадлага, мэдээлэл болон мэргэжилтэн солилцоо, эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг практикт нэвтрүүлэх зэрэг чиглэлд ашиглах.

**3. Гэрээний бүтэц**

Энэхүү гэрээний үзэл баримтлал нь хэлэлцээр хийж буй талуудын хамтын ажиллагааг хангах замаар энэхүү Гэрээнд заагдсан голлох зүйл заалт, тэдгээрийн үндсэн дээр хоёр талын хэрэгжүүлэх хамтарсан судалгааны гэрээ хэлэлцээрийг хэрэгжилтийг хангахад оршино.

**4. Хамтын ажиллагааны нөхцөл**

- а. Талууд мэдээлэл, туршлага солилцох замаар харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэх болно.
- Хамтын ажиллагааны аливаа хэлбэрүүдийг хоёр хүрээлэн, тэдгээрийн салбар нэгж, эсвэл эрдэм шинжилгээний ажилтны түвшинд урьдчилан тохиролцсон нөхцөл, хэрэгжүүлэх хугацаа бүхий тодорхой гэрээ, харилцан тохиролцсон төсөл, ажлын хөтөлбөр зэрэгт үндэслэн хэрэгжүүлнэ.
- Ажлын хөтөлбөр болон төлөвлөгөө нь хамтын ажиллагааны чиглэл болон хэлбэр, түүн дотроо санхүүжилтийг тодорхойлсон байна.
- б. Талууд хамтын ажиллагааг дараах үндсэн чиглэлд хөгжүүлэхээр тохиролцов. Үүнд:
- Харилцан зөвшөөрсөн сэдвийн хүрээнд тодорхой судалгааны ажлыг гүйцэтгэх;
  - Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, нэгэн сэдэвт бүтээл хамтран боловсруулах
  - Олон улсын чанартай эрдэм шинжилгээний бага хурал, симпозиум, семинар хамтран зохион байгуулах;
  - Шинжлэх ухаан, техникийн мэдээлэл солилцох;

- Дэд доктор, докторын диссертаци бэлтгэж, хамгаалах
  - Эрдэм шинжилгээний мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг явуулах, монголын талын хүсэлтээр сургалт, хүний нөөцийг бэлтгэх үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх.
- Энэхүү гэрээний дагуу хоёр тал хамтын ажиллагааг хөгжүүлэхтэй ОХУ, Монгол Улсын засгийн газрын хамтын ажиллагааны эрхзүйн баримт бичиг, хоёр улсын хүрээнд мөрдөгддөг хууль, эрхзүйн баримт бичгийг үндэс болгоно. Мэргэжилтэн солилцох үйл ажиллагаа нь хэлэлцээрийн түвшинд хоёр талын санхүүгийн боломжийн хүрээнд шийдвэрлэгдэнэ.

### 5. Хамтарсан төсөл хэрэгжүүлэх

Өөрийн болон бусад эрдэм шинжилгээний байгууллагын мэргэжилтнийг татан оролцуулсан хамтарсан төслүүдийг бие даасан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх бөгөөд олон улсын төслүүдийг ч мөн үүнд хамруулан ойлгоно.

### 6. Санхүүжилт

Энэхүү гэрээний хүрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр өөр гэрээгээр зохицуулаагүй нөхцөлд талууд хамтарсан төсөл хэрэгжүүлэхэд гарах өөрт хамаарах зардлыг бие даан хариуцна.

Тодорхой төсөл хэрэгжүүлэх нөхцөл болон санхүүжилтийг тэдгээрийг хэрэгжүүлэхээс өмнө 5-р зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

### 7. Гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа, өөрчлөлт болон цуцлах

Хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт болон өөрчлөлт оруулж болно. Гарын үсгээр хүчин төгөлдөр болсон гэрээ нь өөр бусад арга хэмжээ хэрэгжүүлэх, хамтран ажиллах боломжийг үгүйсгэхгүй хэдий ч талууд хэлэлцсэн асуудлаа бичгэн хэлбэрээр баримтжуулсан байна.

Энэхүү гэрээ нь гэрээнд талууд гарын үсэг зурсан хугацаанаас хүчин төгөлдөр болох бөгөөд хугацаагүй болно. Гэрээг цуцлах хүсэлтийг аль нэг тал 6 сарын өмнөөс бичгээр илэрхийлсэн нөхцөлд шийдвэрлэнэ. Гэрээний хүрээнд эхэлсэн болон үргэлжилж буй ажлын үр дүнг гэрээ цуцласнаас үл хамааран өмнө тохиролцсон хэлэлцээрийн хүрээнд дуусгавар болгож хүлээлгэн өгнө.

Энэхүү гэрээг орос болон монгол хэл дээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд бүх хувилбар хуулийн хүрээнд хүчин төгөлдөрт тооцогдоно.

### Талуудын хаяг

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи  
Газарзүй, Геоэкологийн Хүрээлэн  
Баруун Сэлбэ 15, 15170 Улаанбаатар, Монгол  
Утас: (976)-11-322187  
Факс: (976)-11-322187  
email: [info@geo-eco.mn](mailto:info@geo-eco.mn)

ШУА ГГХ төлөөлж захирал, доктор

2015 оны 11 сарын 14 өдөр

ОХУ-ын Шинжлэх Ухааны академийн  
Сибирийн салбарын Л.А.Мелентьевын нэрэмжит  
Системын Эрчим Хүчний Хүрээлэн  
Иркутск хот, Лермонтовын гудамж 130  
Утас: +7(3952)42-47-00  
Факс: +7(3952)42-44-44  
email: [info@isem.irk.ru](mailto:info@isem.irk.ru)

ШУА СС СЭХХ төлөөлж захирлын үүрэг  
Б.Батбуян гүйцэтгэгч

В.А.Стенников

өдөр

